ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН  АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Нэгдсэн Эмнэлгийн  2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: ДГА-2024/05/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас:
www.dornogovi@audit.gov.mn
Дорноговь аймаг Сайншанд сум
2024 он

Дорноговь аймаг дахь төрийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий
Утас: 261665, 70522734 Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn
Аудитын менежер: У.Оюунтүлхүүр
Утас: 70523020 Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn
Ахлах аудитор/аудитор: Д.Сайнжаргал
Утас: 99080493 Цахим хаяг: info.iedca@gmail.com
Интакс Эксперт Ди Си ХХК-ийн захирал: Д.Сайнжаргал
Утас: 99080493 Цахим хаяг: info.iedca@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (976) 7052 2734
Цахим хуудас: dornogovi@audit.gov.mn

2024-02-23 № 1-6/256

танай ______________-ны №______________-т

ЗАМЫН-ҮҮД СУМЫН НЭГДСЭН
ЭМНЭЛГИЙН ДАРГА
У.ЭНХМАА ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Нэгдсэн эмнэлэг 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Замын Үүд сумын Нэгдсэн эмнэлэг 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тайлант онд тус байгууллагын харьяанд 19 айлын орон сууцны барилга бүрэн засвар хийгдэж ашиглалтад орсон бөгөөд үндсэн хөрөнгөөр бүртгэх хүсэлтээ орон нутгийн өмчийн газарт гаргасан байна. Өмч хүлээн авч хөрөнгө нэмж бүртгэх шийдвэр нь 2023 онд гаргаагүйн улмаас тус барилгын сайжруулалттай холбоотой их засварын зардал 465,4 сая төгрөгийн зардлыг 2022, 2023 онуудад урсгал засварын зардлаар, 2023 онд барилгыг худалдан авахад төлсөн төлбөрт төлсөн 350 сая төгрөг нь хөрөнгийн зардлаар бүртгэгдэн Үр дүнгийн тайланд толилуулагдсан байна.байна.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

010000070

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн асуудлуудыг авч үзэх бөгөөд 2023 онд тухайн байгууллагын үйл ажиллагаанд чиглэсэн холбогдох эрх зүйн актуудын хэрэгжилтийг хангаан, мөрдсөн эсэх асуудлыг аудитын гол асуудал гэж үзлээ.

Нийцсэн бөгөөд зохистой байх болон тохиолдсон байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилын дүнд дараах зөрчлүүд илэрсэн бөгөөд холбогдох хуулийн заалтыг зөрчсөн байна. Үүнд:

1. Шилэн дансны тухай хуульд заасан хөрөнгө, мөнгө, зарцуулах тухай захирлын А тушаалыг, шилэн дансанд байршуулсан мэдээлэлтэй тулган шалгахад Хөрөнгө зарцуулах тухай 20 ширхэг тушаалыг шилэн дансанд байршуулаагүй байна.
2. 2023 оны байдлаар иргэдээс үзүүлж байгаа төлбөрт үйлчилгээний орлогын цахим төлбөрийн систем дэх И-баримтын дүн санхүүгийн тайлангийн орлогын дүнгээс зөрүүтэй байна. Энэ нь ЭМС-ын 2022 оны А/216 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан "Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний журам"-ын 3.4-т заасан "И-баримт" заавал олгоно гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.
3. Ebarimt- ийн системд бүртгэлтэй баримтын жагсаалтыг татан авч сар, өдөр давхардсан, ижил дүнтэй, зөрчилтэй, өндөр дүнтэй, нэг харилцагчаас ПОС болон И баримтын системээс нэгэн зэрэг үүсгэгдсэн зэрэг зөрчилтэй байж болох 69 ширхэг 268.5 сая төгрөгийн баримтыг түүвэрлэн авч гэрээ, анхан шатны баримт, төлбөрийн баримтууд руу хөөн шалгахад 33 ширхэг 124.5 сая төгрөгийн И баримт илүү буюу давтагдсан зөрчилтэй байлаа.
4. Машин тоног төхөөрөмж дансанд 22 нэр төрлийн үндсэн хөрөнгийг шууд худалдан авсан байна.

**Бусад асуудлын хэсэг**

АДБОУС 2706.10-д зааснаар хууль тогтоомжоор хориглоогүй аудитын тайланд заавал мэдээлэх аудитын гол асуудал гэж тодорхойлоогүй, тухайлбал аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Т. ГАН-ӨЛЗИЙ

## 1.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,606,290,334.59** | **1,476,784,790.74** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **292,759,537.86** | **8,306,746.24** |
| **31200** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | **292,759,537.86** | **8,306,746.24** |
| **31210** | **Төгрөг** | **292,759,537.86** | **8,306,746.24** |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 292,759,537.86 | 8,306,746.24 |
| **33** | **АВЛАГА** | **3,530,762.35** | **526,516,736.00** |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 272,126.00 | 1,839,336.00 |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | 0.00 | 173,809,100.00 |
| **33500** | **Бусад авлага** | **3,258,636.35** | **350,868,300.00** |
| 33510 | Байгууллагаас авах авлага | 3,247,461.78 | 350,868,300.00 |
| 33520 | Хувь хүмүүсээс авах авлага | 11,174.57 | 0.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **1,310,000,034.38** | **941,961,308.50** |
| **35100** | **Түүхий эд материал** | **1,130,259,996.12** | **741,655,702.40** |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 147,953,599.14 | 203,345,723.14 |
| 35130 | Эм боох материал | 982,306,396.98 | 538,309,979.26 |
| **35400** | **Хангамжийн материал** | **179,740,038.26** | **200,305,606.10** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 406,000.00 | 406,000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 358,127.00 | 6,139,150.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 8,245,111.00 | 760,000.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 19,384,309.00 | 9,309.00 |
| 35460 | Хүнсний материал | 2,589,442.69 | 1,960,851.53 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 148,757,048.57 | 191,030,295.57 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **13,123,459,338.94** | **12,556,571,057.04** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **13,123,459,338.94** | **12,556,571,057.04** |
| **39200** | **Биет хөрөнгө** | **12,889,459,338.94** | **12,322,571,057.04** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 8,840,002,971.03 | 8,840,002,971.03 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -310,120,956.79 | -464,165,050.87 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 385,536,434.00 | 545,536,434.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -164,748,664.73 | -251,136,433.63 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 5,869,451,604.76 | 6,438,883,528.86 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -1,872,404,800.59 | -2,916,708,251.38 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 217,129,313.33 | 247,271,313.33 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -88,417,656.67 | -128,446,515.66 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 58,438,134.66 | 58,438,134.66 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -45,407,040.06 | -47,105,073.30 |
| **39300** | **Биет бус хөрөнгө** | **234,000,000.00** | **234,000,000.00** |
| 39301 | Програм хангамж | 1,060,000.00 | 1,060,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -1,060,000.00 | -1,060,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 234,000,000.00 | 234,000,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **14,729,749,673.53** | **14,033,355,847.78** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **0.00** | **1,091,863,181.55** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **0.00** | **1,091,863,181.55** |
| **41300** | **Өглөг** | **0.00** | **1,091,863,181.55** |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 0.00 | 71,165,556.55 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 0.00 | 1,019,577,625.00 |
| **41360** | **Бусад өглөг** | **0.00** | **1,120,000.00** |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | 0.00 | 1,120,000.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **14,729,749,673.53** | **12,941,492,666.23** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **14,729,749,673.53** | **12,941,492,666.23** |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 949,893,092.00 | 949,893,092.00 |
| 511001 | Улсын төсвийн оруулсан хөрөнгө | 949,893,092.00 | 949,893,092.00 |
| **51200** | **Хуримтлагдсан үр дүн** | **13,511,292,643.85** | **11,723,035,636.55** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 11,699,320,647.43 | 13,511,292,643.85 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 1,811,971,996.42 | -1,788,257,007.30 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 268,563,937.68 | 268,563,937.68 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **14,729,749,673.53** | **14,033,355,847.78** |

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **8,474,826,264.13** | **6,377,525,226.56** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **3,903,732,674.13** | **1,415,292,588.06** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **3,903,732,674.13** | **1,415,292,588.06** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **175,442,254.26** | **269,663,905.00** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 175,442,254.26 | 257,873,905.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 0.00 | 11,790,000.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 2,668,432,443.32 | 662,482,924.10 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 1,059,857,976.55 | 483,145,758.96 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **4,571,093,590.00** | **4,962,232,638.50** |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | **4,571,093,590.00** | **4,962,232,638.50** |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 4,571,093,590.00 | 4,962,232,638.50 |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **6,651,650,755.51** | **8,165,782,233.86** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **6,651,650,755.51** | **7,815,782,233.86** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **6,645,761,069.51** | **7,807,362,312.86** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **2,477,901,210.79** | **3,099,753,809.95** |
| 210101 | Үндсэн цалин | 1,418,382,581.43 | 2,314,769,164.84 |
| 210102 | Нэмэгдэл | 914,150,781.73 | 593,359,874.89 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 56,627,000.89 | 87,655,845.94 |
| 210104 | Урамшуулал | 88,740,846.74 | 103,968,924.28 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **316,000,552.31** | **393,161,511.95** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 216,111,175.36 | 273,914,726.81 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 25,906,950.00 | 31,638,464.09 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 32,826,338.02 | 24,584,170.40 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 5,053,154.89 | 5,579,339.73 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 36,102,934.04 | 57,444,810.92 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **310,647,605.96** | **354,165,759.53** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 42,510,215.56 | 56,577,288.53 |
| 210302 | Түлш, халаалт | 240,248,694.40 | 259,460,142.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 27,888,696.00 | 38,128,329.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **167,152,872.94** | **234,252,252.60** |
| 210401 | Бичиг хэрэг | 11,691,734.00 | 25,509,450.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 77,049,354.00 | 73,815,111.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 14,364,048.94 | 15,706,597.60 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 4,013,100.00 | 11,673,100.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 60,034,636.00 | 107,547,994.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **1,801,354,246.84** | **2,037,041,211.44** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,684,000,782.54 | 1,919,848,780.28 |
| 210502 | Хоол, хүнс | 112,542,984.30 | 117,192,431.16 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 4,810,480.00 | 0.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **361,858,740.00** | **307,937,476.00** |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 1,992,340.00 | 2,257,200.00 |
| 210604 | Урсгал засвар | 359,866,400.00 | 305,680,276.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **7,250,950.00** | **15,223,358.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 7,250,950.00 | 15,223,358.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **53,828,918.00** | **35,713,727.39** |

| | | | |
|---|---|---|---|
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 48,697,890.00 | 17,861,574.39 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 0.00 | 3,460,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 728,550.00 | 601,875.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 265,978.00 | 266,278.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 154,000.00 | 176,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 0.00 | 12,880,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 234,000.00 | 468,000.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 3,748,500.00 | 0.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **1,149,765,972.67** | **1,330,113,206.00** |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 0.00 | 3,651,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 1,149,765,972.67 | 1,326,462,206.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **5,889,686.00** | **8,419,921.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **5,889,686.00** | **8,419,921.00** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 5,889,686.00 | 8,419,921.00 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **0.00** | **350,000,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **0.00** | **350,000,000.00** |
| 220001 | Хаагдсан данс | 0.00 | 350,000,000.00 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | **1,823,175,508.62** | **-1,788,257,007.30** |
| **V** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | **11,203,512.20** | **0.00** |
| 225001 | Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз | 11,203,512.20 | 0.00 |
| **VI** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | **1,811,971,996.42** | **-1,788,257,007.30** |

4417144353
ЕЮА0056 9025707

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **5,686,375,043.86** | **5,056,520,233.50** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **175,442,254.26** | **268,096,695.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **175,442,254.26** | **268,096,695.00** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **175,442,254.26** | **268,096,695.00** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 175,442,254.26 | 256,306,695.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 0.00 | 11,790,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **5,510,932,789.60** | **4,788,423,538.50** |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | **5,510,932,789.60** | **4,788,423,538.50** |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 5,510,932,789.60 | 4,788,423,538.50 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **4,928,779,086.33** | **4,893,882,025.12** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **4,928,779,086.33** | **4,893,882,025.12** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **4,922,889,400.33** | **4,885,210,121.12** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **2,475,406,750.21** | **3,025,629,426.54** |
| 210101 | Үндсэн цалин | 1,293,556,962.85 | 1,700,265,757.47 |
| 210102 | Нэмэгдэл | 992,915,441.75 | 1,051,264,750.34 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 67,408,269.59 | 119,099,019.93 |
| 210104 | Урамшуулал | 121,526,076.02 | 154,999,898.80 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **316,118,963.66** | **392,861,702.46** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 214,932,301.32 | 273,796,314.73 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 26,231,321.34 | 31,638,464.09 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 21,647,380.69 | 24,584,170.40 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 5,118,169.17 | 5,579,339.73 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 48,189,791.14 | 57,263,413.51 |

| | | | |
|---|---|---|---|
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **311,647,605.96** | **222,195,532.52** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 43,510,215.56 | 60,853,611.92 |
| 210302 | Түлш, халаалт | 240,248,694.40 | 132,866,751.60 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 27,888,696.00 | 28,475,169.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **167,038,124.94** | **198,641,872.60** |
| 210401 | Бичиг хэрэг | 12,032,329.00 | 21,414,500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 79,167,965.00 | 94,000,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 14,364,048.94 | 15,706,597.60 |
| 210404 | Ном, хэвлэл | 0.00 | 0.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 4,013,100.00 | 11,673,100.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 57,460,682.00 | 55,847,675.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **1,187,005,697.56** | **687,621,958.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,056,216,132.56 | 567,447,678.00 |
| 210502 | Хоол, хүнс | 113,648,885.00 | 106,805,550.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 17,140,680.00 | 13,368,730.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **404,369,890.00** | **306,636,200.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 14,963,150.00 | 10,625,000.00 |
| 210602 | Тавилга | 0.00 | 3,303,300.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 2,757,440.00 | 2,707,900.00 |
| 210604 | Урсгал засвар | 386,649,300.00 | 290,000,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **7,250,950.00** | **14,820,375.00** |
| 210701 | Гадаад албан томилолт | 0.00 | 0.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 7,250,950.00 | 14,820,375.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **54,051,418.00** | **32,857,054.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 48,697,890.00 | 15,091,401.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 0.00 | 800,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 728,550.00 | 601,875.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 265,978.00 | 266,278.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 154,000.00 | 176,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 0.00 | 13,358,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 234,000.00 | 468,000.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 3,971,000.00 | 2,095,500.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **0.00** | **3,946,000.00** |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 0.00 | 3,946,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **5,889,686.00** | **8,671,904.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **5,889,686.00** | **8,671,904.00** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 5,889,686.00 | 8,671,904.00 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **757,595,957.53** | **162,638,208.38** |
| **V** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | **465,605,830.00** | **447,091,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **465,605,830.00** | **447,091,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **465,605,830.00** | **447,091,000.00** |
| 220001 | Барилга байгууламж | 0.00 | 350,000,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 465,605,830.00 | 97,091,000.00 |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | **-465,605,830.00** | **-447,091,000.00** |
| **VIII** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **291,990,127.53** | **-284,452,791.62** |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 769,410.33 | 292,759,537.86 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 292,759,537.86 | 8,306,746.24 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| 1 | 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 949,893,092.00 | 268,626,382.68 | 11,705,336,983.07 | 12,923,856,457.75 |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | -6,016,335.64 | -6,016,335.64 |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 949,893,092.00 | 268,626,382.68 | 11,699,320,647.43 | 12,917,840,122.11 |
| 4 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | 0.00 | -62,445.00 | 0.00 | -62,445.00 |
| 9 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 1,811,971,996.42 | 1,811,971,996.42 |
| 10 | 2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 949,893,092.00 | 268,563,937.68 | 13,511,292,643.85 | 14,729,749,673.53 |
| 11 | 2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 949,893,092.00 | 268,563,937.68 | 13,511,292,643.85 | 14,729,749,673.53 |
| 13 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 949,893,092.00 | 268,563,937.68 | 13,511,292,643.85 | 14,729,749,673.53 |
| 19 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | -1,788,257,007.30 | -1,788,257,007.30 |
| 20 | 2023 оны 6-р сарын 30-наарх үлдэгдэл | 949,893,092.00 | 268,563,937.68 | 11,723,035,636.55 | 12,941,492,666.23 |

4417144353
ЕЮА0056 9025707

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Төсвийн гүйцэтгэлийн тайлан | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **6,496,813,500.00** | **5,340,973,025.12** | **1,155,840,474.88** | **82%** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **6,146,813,500.00** | **4,990,973,025.12** | **1,155,840,474.88** | **81%** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **6,134,813,500.00** | **4,982,301,121.12** | **1,152,512,378.88** | **81%** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **3,062,049,000.00** | **3,025,629,426.54** | **36,419,573.46** | **99%** |
| 210101 | Үндсэн цалин | 1,900,000,000.00 | 1,700,265,757.47 | 199,734,242.53 | 89% |
| 210102 | Нэмэгдэл | 883,290,600.00 | 1,051,264,750.34 | -167,974,150.34 | 119% |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 94,116,100.00 | 119,099,019.93 | -24,982,919.93 | 127% |
| 210104 | Урамшуулал | 184,642,300.00 | 154,999,898.80 | 29,642,401.20 | 84% |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **439,914,700.00** | **392,861,702.46** | **47,052,997.54** | **89%** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 303,964,500.00 | 273,796,314.73 | 30,168,185.27 | 90% |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 35,431,600.00 | 31,638,464.09 | 3,793,135.91 | 89% |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 27,769,800.00 | 24,584,170.40 | 3,185,629.60 | 89% |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 6,542,900.00 | 5,579,339.73 | 963,560.27 | 85% |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 66,205,900.00 | 57,263,413.51 | 8,942,486.49 | 86% |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **421,693,300.00** | **222,195,532.52** | **199,497,767.48** | **53%** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 68,003,100.00 | 60,853,611.92 | 7,149,488.08 | 89% |
| 210302 | Түлш, халаалт | 271,027,200.00 | 132,866,751.60 | 138,160,448.40 | 49% |
| 210303 | Цэвэр, бохир ус | 82,663,000.00 | 28,475,169.00 | 54,187,831.00 | 34% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **212,704,000.00** | **198,641,872.60** | **14,062,127.40** | **93%** |
| 210401 | Бичиг хэрэг | 23,984,000.00 | 21,414,500.00 | 2,569,500.00 | 89% |
| 210402 | Тээвэр, шатахуун | 96,000,000.00 | 94,000,000.00 | 2,000,000.00 | 98% |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 19,920,000.00 | 15,706,597.60 | 4,213,402.40 | 79% |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 14,000,000.00 | 11,673,100.00 | 2,326,900.00 | 83% |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 58,800,000.00 | 55,847,675.00 | 2,952,325.00 | 95% |
| **2105** | **Нормативт зардал** | **1,154,543,000.00** | **687,621,958.00** | **466,921,042.00** | **60%** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,022,000,000.00 | 567,447,678.00 | 454,552,322.00 | 56% |
| 210502 | Хоол, хүнс | 118,095,000.00 | 106,805,550.00 | 11,289,450.00 | 90% |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 14,448,000.00 | 13,368,730.00 | 1,079,270.00 | 93% |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **467,720,000.00** | **403,727,200.00** | **63,992,800.00** | **86%** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 106,000,000.00 | 94,274,000.00 | 11,726,000.00 | 89% |
| 210602 | Тавилга | 60,000,000.00 | 16,745,300.00 | 43,254,700.00 | 28% |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 11,720,000.00 | 2,707,900.00 | 9,012,100.00 | 23% |
| 210604 | Урсгал засвар | 290,000,000.00 | 290,000,000.00 | 0.00 | 100% |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **14,945,000.00** | **14,820,375.00** | **124,625.00** | **99%** |
| 210702 | Дотоод албан томилолт | 14,945,000.00 | 14,820,375.00 | 124,625.00 | 99% |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **357,298,500.00** | **32,857,054.00** | **324,441,446.00** | **9%** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 329,344,500.00 | 15,091,401.00 | 314,253,099.00 | 5% |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 2,500,000.00 | 800,000.00 | 1,700,000.00 | 32% |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1,050,000.00 | 601,875.00 | 448,125.00 | 57% |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 700,000.00 | 266,278.00 | 433,722.00 | 38% |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 350,000.00 | 176,000.00 | 174,000.00 | 50% |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 16,000,000.00 | 13,358,000.00 | 2,642,000.00 | 83% |
| 210807 | Газрын төлбөр | 1,234,000.00 | 468,000.00 | 766,000.00 | 38% |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 120,000.00 | 0 | 120000 | 0% |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 6,000,000.00 | 2,095,500.00 | 3,904,500.00 | 35% |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **3,946,000.00** | **3,946,000.00** | **0.00** | **100%** |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,946,000.00 | 3,946,000.00 | 0.00 | 100% |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **12,000,000.00** | **8,671,904.00** | **3,328,096.00** | **72%** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **12,000,000.00** | **8,671,904.00** | **3,328,096.00** | **72%** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 12,000,000.00 | 8,671,904.00 | 3,328,096.00 | 72% |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **350,000,000.00** | **350,000,000.00** | **0.00** | **100%** |
| 220001 | Барилга байгууламж | 350,000,000.00 | 350,000,000.00 | 0.00 | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| III | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **6,496,813,500.00** | **5,056,520,233.50** | **1,440,293,266.50** | **78%** |
| 33 | **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **5,953,894,000.00** | **4,788,423,538.50** | **1,165,470,461.50** | **80%** |
| 330002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 5,953,894,000.00 | 4,788,423,538.50 | 1,165,470,461.50 | 80% |
| 35 | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **542,919,500.00** | **268,096,695.00** | **274,822,805.00** | **49%** |
| 350001 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 240,000,000.00 | 256,306,695.00 | -16,306,695.00 | 107% |
| 350002 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 10,160,000.00 | 11,790,000.00 | -1,630,000.00 | 116% |
| 350003 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 292,759,500.00 | 0 | 292,759,500.00 | 0% |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0 | 292,759,537.86 | -292,759,537.86 | |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0 | 8,306,746.24 | -8,306,746.24 | |

4417144353
ЕЮА0056 9025707

**2.7 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

Тайлант онд нэмэлт санхүүжилт ороогүй байна.

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

*Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар*

Дорноговь аймгийн Замын Үүд сумын Нэгдсэн Эмнэлэг нь эрүүл мэндийн үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй ил тод шуурхай хүргэх, иргэдийг мэдээллээр хангах зорилго, чиг үүргийг хэрэгжүүлж ажилласан байна.

Монгол улсын Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуульд өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв нь "эмнэлгийн мэргэшсэн тусламж, үйлчилгээ, эх барихын тусламж, үйлчилгээ, сувилахуйн болон сэргээн засахын дагнасан тусламж, үйлчилгээ шаардлагатай иргэнийг холбогдох эрүүл мэндийн байгууллагад илгээх, эргэх холбоо тогтоох, тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах, харьяа нутаг дэвсгэрийн хүн амын дунд нийгмийн эрүүл мэндийг дэмжих, хамгаалах хөтөлбөр, арга хэмжээг зохион байгуулж, хэрэгжүүлэх, сум, тосгоны эрүүл мэндийн төв түргэн тусламжийн үйлчилгээ үзүүлэх зэрэг чиг үүргийг хэрэгжүүлнэ гэж тодорхойлжээ.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Дорноговь аймгийн Замын Үүд сумын Нэгдсэн Эмнэлэг нь Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулиудыг үндсэн үйл ажиллагаандаа мөрдөж ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төрийн хэмнэлтийн тухай хууль 2023.06.16-ны өдөр нэмэлт, 2023.07.07-ны өдөр нэмэлт өөрчлөлт орсон
- Төсвийн тухай хууль 2023.07.07-ны өдөр нэмэлт өөрчлөлт орсон

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 3,194.4 сая төгрөгийн алдаа[1] илэрснээс аудитын явцад 2,911.3 сая төгрөгийн алдааг залруулж, 283.1 сая төгрөгийн алдааг дахин давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өглөө.

*Залруулсан алдаа:*

- Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал тооцоолол алдаатай тооцогдож байгаа нь үнэлгээ батламж мэдэгдлийг хангахгүй байгаа
- Аккурэл сууриар бүртгээгүй гүйлгээ нь толилуулга ба тодруулга батламж мэдэгдлийг хангахгүй байгаа

**5.1 Төлбөрийн акт**

Аудитаар төлбөрийн акт хүргүүлээгүй болно.

**5.2 Албан шаардлага**

Аудитаар төлбөрийн Албан шаардлага хүргүүлээгүй болно

**5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал

<u>*Илрүүлэлт:*</u> . Машин тоног төхөөрөмж дансанд 22 нэр төрлийн үндсэн хөрөнгийг шууд худалдан авалт хийсэн.

<u>*Өгсөн зөвлөмж:*</u> / Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14.1.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан захиалагч нь тухайн жилд худалдан авах 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг өмнөх онд худалдан авсан тоо хэмжээ, нэгж үнийн хамт төрийн худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14.4.Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно гэж заасныг биелүүлж ажиллах.

2. Е баримттай холбоотой асуудал

<u>*Илрүүлэлт:*</u>

Ebarimt-ийн системд бүртгэлтэй баримтын жагсаалтыг татан авч сар, өдөр давхардсан, ижил дүнтэй, зөрчилтэй, өндөр дүнтэй, нэг харилцагчаас ПОС болон И баримтын системээс нэгэн зэрэг үүсгэгдсэн зэрэг зөрчилтэй байж болох 69 ширхэг 268.5 сая төгрөгийн баримтыг түүвэрлэн авч гэрээ, анхан шатны баримт, төлбөрийн баримтууд руу хөөн шалгахад 33 ширхэг 124.5 сая төгрөгийн И баримт илүү буюу давтагдсан зөрчилтэй байлаа.

<u>*Өгсөн зөвлөмж:*</u>

НББ-ийн тухай хуулийн 13.5.Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна, НӨАТ-ийн тухай хуулийн 17.6 "Албан татвар суутган төлөгч

---

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон... бол татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй" хэрэгжүүлж ажиллах

*Илрүүлэлт:* "2023 оны байдлаар иргэдээс үзүүлж байгаа төлбөрт үйлчилгээний орлогын цахим төлбөрийн систем дэх И-баримтын дүн санхүүгийн тайлангийн орлогын дүнгээс зөрүүтэй байна. Энэ нь ЭМС-ын 2022 оны А/216 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан "Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний журам""-ын 3.4-т заасан ""И-баримт"" заавал олгоно гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна."
*Өгсөн зөвлөмж:* ЭМС-ын 2022 оны А/216 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан "Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний журам""-ын 3.4-т заасан ""И-баримт"" заавал олгоно гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 08 дугаар сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс Залруулсан | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Санхүүгийн байдлын тайланд эдийн засгийн шинжилгээ хийж үзэхэд үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал хэт өндөр өөрчлөлттэй гарсан тул дахин тооцоолол хийж үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг залруулсан. | 1 | 1,001,945.42 | | | 1 | 1,001,945.42 | 1 | 1,001,945.42 |
| Аккурэл сууриар бүртгээгүй гүйлгээг залруулсан. | 1 | 1,909,402.74 | | | 1 | 1,909,402.74 | 1 | 1,909,402.74 |
| **ДҮН** | **2** | **2,911,348.16** | **0** | **-** | **2** | **2,911,348.16** | **2** | **2,911,348.16** |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**
**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| **Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил** | | | | | | | | |
| Шилэн дансны тухай хуульд заасан хөрөнгө, мөнгө, зарцуулах тухай захирлын А тушаалыг, шилэн дансанд байршуулсан мэдээлэлтэй тулган шалгахад Хөрөнгө зарцуулах тухай 20 ширхэг тушаалыг шилэн дансанд байршуулаагүй | 1 | 74,895.20 | | | | | 1 | 74,895.20 |
| ДҮН | 1 | 74,895.20 | | | | | 1 | 74,895.20 |

| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2023 оны байдлаар иргэдээс үзүүлж байгаа төлбөрт үйлчилгээний орлогын цахим төлбөрийн систем дэх И-баримтын дүн санхүүгийн тайлангийн орлогын дүнгээс зөрүүтэй байна. Энэ нь ЭМС-ын 2022 оны А/216 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан "Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний журам"-ын 3.4-т заасан "И-баримт" заавал олгоно гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна. | **1** | **-** | | | | | **1** | **-** |
| Ebarimt- ийн системд бүртгэлтэй баримтын жагсаалтыг татан авч сар, өдөр давхардсан, ижил дүнтэй, зөрчилтэй, өндөр дүнтэй, нэг харилцагчаас ПОС болон И баримтын системээс нэгэн зэрэг үүсгэгдсэн зэрэг зөрчилтэй байж болох 69 ширхэг 268.5 сая төгрөгийн баримтыг түүвэрлэн авч гэрээ, анхан шатны баримт, төлбөрийн баримтууд руу хөөн шалгахад 33 ширхэг 124.5 сая төгрөгийн И баримт илүү буюу давхардсан зөрчилтэй байлаа. | **1** | 124,574.37 | | | | | **1** | 124,574.37 |
| Машин тоног төхөөрөмж дансанд 22 нэр төрлийн үндсэн хөрөнгийг шууд худалдан авсан байна. | 1 | 83,649.00 | | | | | 1 | 83,649.00 |
| ДҮН | **3** | **208,223.37** | | | | | **3** | **208,223.37** |